



ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

20~~22~~ оны 09 сарын 15 өдөр

№ 06/22

Улаанбаатар хот

Г “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийн
Хөрөнгө оруулалтын бодлого батлах тухай”

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 12.1.10 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийн “Хөрөнгө оруулалтын бодлого”-ыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан “Ди Би Эм ассет менежмент УЦК” -ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 16/18 дугаар тогтоол хүчингүй болсонд тооцсугай.
3. “Хөрөнгө оруулалтын бодлого”-ыг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандaa чанд мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Мөнхбат/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт, шалгалт хариуцсан ажилтанд даалгасугай.





ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Баримтын хувилбар 2.0

Огноо 2022/09/15

Журмын код:

Компанийн дотоод хэрэгцээнд ашиглана.




Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗНБДарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/.../....	Хуудас 2 /7

БАРИМТ БИЧИГТ ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

ЖУРМЫГ БАТАЛСАН:

ОГНОО	ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД	Гарын үсэг
2022/.... /....	Л.Тэмүүжин (ТУЗ-ийн дарга)	

ЖУРМЫГ ХЯНАСАН:

ОГНОО	ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД	ГАРЫН ҮСЭГ
2022//....	Д.Мөнхбат (Гүйцэтгэх захирал)	
2022//....	М.Жавхлан (Сангийн менежер)	
2022//....	Ш. Мөнхцэцэг (Захиргаа, хүний нөөцийн ахлах мэргэжилтэн)	
2022/.../...	М.Түвшинбагана (ТХН-ийн Санхүүгийн мэргэжилтэн)	

ЖУРМЫГ БОЛОВСРУУЛСАН:

ХУВИЛБАР №	ОГНОО	АЖИЛТАН	ТАЙЛБАР
1.0	2018.06.26		2018.06.26-ны өдрийн 16/118 дугаар “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор батлагдан хүчин төгөлдөр болсон.
2.0	2022/01/14	Д.Нэрэнцогт (ТХН-ийн хуулийн зөвлөх)	2021.11.23-ны шинэчилсэн Компанийн дүрмийн өөрчлөлт болон компанийн бүтцийн өөрчлөлттэй уялдуулан өөрчлөв.

Хамрах хүрээ: "Ди Би Эм ассет менежмент УЦК" ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗНБДарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/.../....	Хуудас 3 /7

АГУУЛГА

- НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
 ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФИЛОСОФИ
 ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ
 БОДЛОГО
 ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ
 ЗАРЧИМ
 ТАВ. БУСАД



ДИ Е
 (ЕНЕ)

11182



Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗНБДарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/.../....	Хуудас 4 /7

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК / цаашид “компани” гэх / -ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд баримтлах бодлого, зарчмыг тодорхойлоход энэхүү хөрөнгө оруулалтын бодлогын зорилго оршино.
- Компани нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 13.1-д болон Монгол Улсын Хөгжлийн банкны Хөрөнгө оруулалтын бодлогын 2 дугаар зүйлд заасан бодлогоос гадна энэхүү бодлогыг удирдлага болгоно.

ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФИЛОСОФИ

- Компанийн хөрөнгө оруулалтын философи нь Монгол Улсын эдийн засгийн олон тулгуурт суурь бүтцийг оновчтой бүрдүүлэх зорилгоор тогтвортой ногоон санхүүжилтийн зарчмыг баримтлан эдийн засагт тэргүүн ээлжид хэрэгжүүлэх шаардлагатай дунд болон урт хугацаатай төслүүдийг төр хувийн хэвшлийн түншлэлийн сайн жишигт суурилан гадаад дотоодын мэргэшсэн хөрөнгө оруулагчидтай хамтарч эрсдэл өгөөжийн зохистой түвшинд амжилттай санхүүжүүлсэн түүхийг бүтээхэд оршино.

ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ БОДЛОГО

- Үр ашигтай, дунд болон урт хугацаат хөрөнгө оруулалт
Мөнгөн урсгалын төсөөлөл нь тодорхой, холбогдох гэрээ, хэлцлээр баталгаажсан, санхүүгийн болон эдийн засгийн хувьд үр ашигтай, дунд болон урт хугацааны төсөл, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийнэ.
- Төслүүдийг эрэмбэлэх
Хөрөнгө оруулах төслийг сонгохдоо улс орны эдийн засагт үзүүлэх шууд болон шууд бус нөлөөлөл, ажлын байр, бүтээмж, нэмүү өртөг, экспортод чиглэсэн, импортыг орлож байгаа эсэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлж байгаа байдлыг харгалzan эрэмбэлэх бодлого баримтална.
- Улс орны хөгжилд тэргүүлэх ач холбогдолтой төслийн санхүүжүүлэх
“Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд 2030”, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдуулан Монгол Улсын эдийн засгийн олон тулгуурт суурь бүтцийг оновчтой бүрдүүлэхэд тэргүүн ээлжид хэрэгжүүлэх шаардлагатай төслүүдийг санхүүжүүлэхэд анхаарна. Мөн түүнчлэн эдгээр төслүүдийн хөгжүүлэлтийг санхүүжүүлэхэд оролцож болно.
- Хамтран санхүүжүүлэх

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗНБДарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/.../....	Хуудас 5 /7

Сангийн хөрөнгө оруулалтыг хөшүүрэг хэлбэрээр ашиглан гадаад, дотоодын мэргэшсэн банк санхүүгийн байгууллагуудтай хамтран төслийг санхүүжүүлэхийг зорино.

3.5 Хөрөнгө оруулалтын уян хатан байдал

Холбогдох хууль тогтоомж, сангийн бодлогод нийцсэн санхүүгийн хэрэгслүүдийг зохистой хослуулах замаар хөрөнгө оруулалтын уян хатан байдлыг хангана.

3.6 Төрийн өмчит компаниудын хэрэгжүүлж буй төслүүд дэх компанийн оролцоо

Гадаад, дотоодын мэргэшсэн хөрөнгө оруулагчидтай хамтрах боломжтой тохиолдолд төрийн өмчийн оролцоотой компаниудын хэрэгжүүлж буй төслүүдэд хөрөнгө оруулна.

ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

4.1 Мэргэжлийн шийдвэр гаргах чадавх бүхий баг

Мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага бүхий хөрөнгө оруулалтын зөвлөх, менежер, судлаач зэргээс бүрдсэн мэргэжлийн баг бүрдүүлж ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд салбарын зөвлөхүүдийг гэрээгээр ажиллуулна.

4.2 Тооцоо судалгаанд үндэслэх

Хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцүүлэхийн тулд бодит мэдээлэл, нарийн тооцоо судалгаанд үндэслэн хөрөнгө оруулалт хийх зарчмыг чанд баримтална.

4.3 Эрсдэлийн удирдлага

Хөрөнгө оруулалтын хязгаар, хориглох зүйлсийг урьдчилан тодорхойлж, эрсдэлийн удирдлагын бодлогод тусган чанд мөрдөж ажиллах бөгөөд эрсдэлээс сэргийлэх арга, хэрэгслийг зохистой ашиглах зарчмыг баримтална. Санхүүгийн хэрэгслийн хэт төвлөрлөөс үүдэн их хэмжээний алдагдал хүлээхээс сэргийлэх зорилгоор хөрөнгийг тараан байршуулна.

4.4 Бие даасан, хараат бус байдал

Менежментийн үйлчилгээ үзүүлэхдээ хөрөнгө оруулагчдын эрх ашигийг эрхэмлэн, бие даан хараат бусаар шийдвэр гаргах, сонирхлын зөрчлөөс зайлсхийх зарчмыг баримтална.

4.5 Хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлэх

Оруулсан хөрөнгийн хадгалалт, ашиглалтын зохистой байдлыг хангах, санхүүгийн хэрэгслийг бодитой үнэлэх боломжийг хангахуйц хэлбэрээр хяналтын тогтолцоог бүрдүүлж ажиллана.

4.6 Компанийн сайн засаглал



Хамрах хүрээ: "Ди Би Эм ассет менежмент УЦК" ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗНБДарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/.../....	Хуудас 6 /7

Компанийн засаглалын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг төлөвшүүлсэн, төлөвшүүлэхээр зорьж буй компанийд хөрөнгө оруулна. Мөн өөрийн компанийн үйл ажиллагаанд сайн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлнэ.

4.7 Хөрөнгө оруулалтын ил тод байдал

Хөрөнгө оруулагчдын бодлого зорилгод нийцсэн хэмжээнд сангийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллана.

4.8 Хөрөнгө оруулалтаас гарах стратеги

Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахын өмнө тухайн хөрөнгө оруулалтаас гарах стратегийг урьдчилан тодорхойлсон байна.

4.9 Хариуцлагатай хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт нь үр ашигтай байхын зэрэгцээ байгаль орчинд ноцтой сөрөг нөлөөгүй, нийгмийн хариуцлагатай, тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн байхад анхаарна. Дараах төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулахгүй байх зарчмыг чанд баримтална. Үүнд :

- 4.9.1 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд харшилсан;
- 4.9.2 Байгаль орчинд ихээхэн хэмжээний сөрөг нөлөө учруулахуйц;
- 4.9.3 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх;
- 4.9.4 Архи тамхи, зэвсгийн болон хорт хог хаягдал бүхий үйлдвэрлэл, мөрийтэй тоглоомын бизнес эрхлэх, цэрэг дайны үйл ажиллагааг санхүүжүүлэх;
- 4.9.5 Бусад хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа;

ТАВ. БУСАД

5.1 Энэхүү журмаар зохицуулагдаагүй асуудлыг тухайн асуудлын талаарх тусгайлан зохицуулсан холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, эсхүл компанийн удирдлагын шийдвэрээр зохицуулна.

--00--



Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗНБДарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/.../....	Хуудас 7 /7

ЖУРМЫН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

ЭНЭХҮҮ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙГ “ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК” ХХКОМПАНИЙН ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР АШИГЛАХ, ТҮГЭЭХ, ТАРААХ, НИЙТИЙН ХУРТГЭЭЛ БОЛГОХЫГ ХОРИГЛОНО.